

ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ



ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

# Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн тайлан

УЛААНБААТАР ХОТ  
2025 ОН

## ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

### МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 06 дугаар сарын 18

Улаанбаатар хот

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
1.1	<p>НЭГ. ЧИГ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ</p> <p>Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн</p>	<p><b>Алсын хараа:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Хүний нөөцийн мэргэжлийн чадамж, тусламж үйлчилгээний чанараар Нийслэлийн хэмжээнд тэргүүлж ажиллана.</li> </ul> <p><b>Эрхэм зорилго:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Нийгмийн эрүүл мэнд (нийтийн эрүүл мэнд) болон төрөлжсөн мэргэшлийн нотолгоонд суурилсан эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн, ухаалаг технологи, инновацийг дэмжин үзүүлэхэд оршино.</li> </ul> <p><b>Эрхэмлэх үнэт зүйл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Үйлчүүлэгч</li> <li>✓ Хамт олон, хувь хүн</li> <li>✓ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй</li> </ul> <p><b>“ Уриа”</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Эко дүүргийн -Эрүүл иргэн</li> </ul> <p><b>Үйл ажиллагааны стратегийн зорилго:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Үйлчлүүлэгчийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний шинэ дэвшилтэт техник, ухаалаг технологи, инновацийн тусламжтайгаар эрүүл мэндийн лавлагаа шатлалын тусламж үйлчилгээг үзүүлнэ.</li> </ul>	100%

**Стратегийн зорилго ба салбар, нутаг дэвсгэрийн нэгж байгууллагын бүтцийн уялдаа:**

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Алсын хараа-2050", Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Эко-Эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, оношилгоо, эмчилгээний удирдамж, стандарт, арга зүйн зөвлөмж боловсруулах, нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, халдварт болон халдварт бус өвчлөл, эндэгдлийн тархалт, нас баралтын тандалтын тогтолцоог бүрдүүлэх, судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

1. Үйлчлүүлэгчийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан лавлагаа шатлалын тусламж, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах

2. Чиг үүрэг, эрхэм зорилго, стратегийн зорилтын хүрээнд хэтийн болон дунд хугацааны төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөр, эрсдэлийн удирдлагын журам боловсруулан, хэрэгжилтийг хангах

3. Халдварт болон Халдварт бус өвчлөл, эндэгдлийн судалгаа, шинжилгээ хийж, эрүүл мэндийг сайжруулах, өвчлөл, эндэгдлийг бууруулах, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, нотолгоонд суурилсан бодлого, хөтөлбөр боловсруулах асуудлаар төрийн захиргааны төв болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах

4. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэжил эзэмшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалт, ажлын байран дахь сургалтыг тасралтгүй зохион байгуулах

5. Эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийн шалтгааныг тодорхойлох судалгаа хийж, эх, хүүхдэд зонхилон тохиолдох өвчлөл, эндэгдлийн тандалтын тогтолцоог бүрдүүлэх, өвчнөөс сэргийлэх

6. Эрүүл мэндтэй холбоотой үндэсний хөтөлбөр, стратеги хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах

7. Эрдэм судлалын ажлыг дэмжин анагаах ухааны ололт амжилт, оношилгоо эмчилгээний дэвшилтэт арга, технологийг эмчилгээ, үйлчилгээнд нэвтрүүлэх, үр дүнг тооцож ажиллах

		<p>8. Үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн хэрэгжүүлэх, нөхцлийг бүрдүүлж, алсын зайн анагаах ухааныг хөгжүүлэх</p> <p>9. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах</p>	
1.2	<p>Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг</p>	<p>Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн "Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн дүрэм, бүтэц, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай" А/86 дугаар тушаалаар бүтэц орон тоог баталсан. Хан-Уул дүүргийн хүн амд хоёдугаар шатлал буюу лавлагаа шатлалын тусламж үйлчилгээг үзүүлдэг.</p> <p>Хаяг: Чингисийн өргөн чөлөө, 20 дугаар хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17042          Утас/факс: (976-11) 77000106,          Шуудангийн хаяг: 17042          Цахим шуудан: <a href="mailto:info@huent.ub.gov.mn">info@huent.ub.gov.mn</a>          Цахим хуудас: <a href="http://www.huemn.ub.gov.mn">www.huemn.ub.gov.mn</a>          Сошиал хуудас: <a href="https://www.facebook.com/Huemt.Official">https://www.facebook.com/Huemt.Official</a></p>	100%



	хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж	
1.4	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	<p>Монгол Улсын хууль, тогтоомж, Улсын их хурал, Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлиг, Монгол Улсын Засгийн газрын тогтоол, шийдвэр, Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн эрүүл мэндийн газрын тушаал, Дүүргийн засаг даргын захирамж тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон Дүүргийн засаг даргын Тамгын газарт байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилт болон бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг шаардсан хугацаанд нь багтаан хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар Эрүүл мэндийн төвд дээд газраас ирсэн тушаал, захирамж, албан даалгавар, зөвлөмж нийт 32 албан бичиг ирсэн бөгөөд тухай бүр биелэлтийг хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эрүүл мэндийн сайдын албан даалгавар-2</li> <li>• Эрүүл мэндийн сайдын тушаал-5</li> <li>• Нийслэлийн засаг даргын тамгын газрын улсын байцаагчийн зөвлөмж-1</li> <li>• Нийслэлийн засаг даргын захирамж-5</li> <li>• Нийслэлийн эрүүл мэндийн газрын албан даалгавар-1</li> <li>• Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын тушаал-10</li> <li>• Хан-Уул дүүргийн засаг даргын захирамж-4</li> <li>• Хан-Уул дүүргийн онцгой комиссын тушаал, албан даалгавар-3 ирсэн байна.</li> </ul> <p style="text-align: right;">96%</p>
1.5	Хөгжлийн төлөвлөлтийн бодлого, бичгийн хэрэгжилтийн баримт хэрэгжилтийн тайлан	<p>Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилго, 10 зорилт, 80 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулахдаа Засгийн газрын 301 дүгээр тогтоолын хүрээнд Нийслэлийн эрүүл мэндийн газар, Дүүргийн засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадуудаас саналын авч тусган батлуулсан. Төлөвлөгөөний биелэлт болон бусад тайлан, хөтөлбөрийн биелэлтийг батлагдсан загварын дагуу Нийслэлийн эрүүл мэндийн газар болон Дүүргийн Засаг даргын тамгын газрын холбогдох хэлтэс, албан тушаалтанд албан бичиг болон цахим хэлбэрээр тухай бүр хүргүүлж, биелэлтийг ханган ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">98%</p>

1.6	<p>Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт</p>	<p>Байгууллагын үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн актууд:</p> <ul style="list-style-type: none"> <li>● Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль</li> <li>● Хөдөлмөрийн тухай хууль</li> <li>● Эрүүл мэндийн тухай хууль</li> <li>● Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль</li> <li>● Төсвийн тухай хууль</li> <li>● Төрийн албаны тухай хууль</li> <li>● Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоол</li> <li>● Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 491 дүгээр тогтоол</li> <li>● Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 84 дүгээр тогтоол</li> <li>● Эрүүл мэндийн салбарын 2024-2025 оны хамт(тариф)-ын хэлэлцээр</li> <li>● Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоол</li> <li>● Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/221 дүгээр тушаал</li> <li>● Эзлжийн амралт олгох, эзлжийн амралтын цалин тооцох журам</li> <li>● НЭМГ даргын 2020 оны А/29 дүгээр тушаалаар "Эмч эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудад үр дүнгийн урамшуулал олгох" журам</li> <li>● НЭМГ-ын 2022 оын 10 сарын 20-ний А/215 "Журам шинэчлэн батлах тухай"</li> <li>● МУ-ын ХНХ сайдын 2017 А/139 тушаалаар "Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт" 08 өөрчөлт оруулах тухай тушаал</li> <li>● Ажлын цаг ашиглалтын журам</li> <li>● ХУЭМТ, ҮЭХорооны хамтарсан "Хамтын гэрээ"-г Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг тус тус мөрдлөгө болгон ажиллаж байна.</li> </ul> <p style="text-align: right;">98%</p>
-----	---	--

1.7	<p>Албан тодорхойлолт, тушаалны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, харилцах албаны цахим шуудангийн хаяг</p> <p>тушаалын албан /эх/-ийн нэр, албаны дугаар, утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг</p>	<p>Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо  Эрүүл мэндийн төвийн дарга Н.Наранбаатар  Утасны дугаар: 77001003  Албаны цахим хуудасны хаяг: <a href="mailto:naranbaatar.n@huemt.ub.gov.mn">naranbaatar.n@huemt.ub.gov.mn</a></p>	100%
-----	---	--	------

1.8	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ тайлан,	<p>Эрүүл мэндийн төвд 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар нийт 242 өргөдөл гомдол ирснээс 139 нь талархал байна. Энэ нь нийт өргөдөл, гомдлын 68%-ийг эзэлж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Гомдол-68 буюу 28,09%</li> <li>✓ Талархал-164 буюу 67,76 %</li> <li>✓ Санал-3 буюу 1,23%</li> <li>✓ Хүсэлт-7 буюу 2,89%</li> </ul> <p><b>Хандалтаар нь авч үзвэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Өрхийн эрүүл мэндийн төвтэй холбоотой -138 буюу 57,02%</li> <li>✓ Эрүүл мэндийн төвтэй холбоотой 104 буюу -42,97%</li> </ul> <p>Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2 хоног 9 цагтай.</p> <p>Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл байхгүй.</p> <p>Шийдвэрлэлтийн дундаж хувь 99%-тай байна. Зөрчил гаргасан албан тушаалтан байхгүй.</p> <p>96%</p> <p>Мөн онтой харьцуулан үзэхэд талархал 9%-иар өссөн, гомдол 8%-иар буурсан үзүүлэлттэй байна. Өргөдөл, гомдол, албан бичгийг бүх талаар нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэйгээр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгөх, хариуцлагагүй хандсан албан хаагч болон удирдлагад хариуцлага тооцож ажиллах үүрэг чиглэлийн дагуу дараах ажлуудыг хийж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Төвийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн "Ажлын сахилга, хариуцлагыг сайжруулах тухай" А/03 дугаар тушаалаар төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.</li> <li>✓ Ирсэн бичиг, өргөдөл гомдлын мэдээг 14 хоног тутам удирдлагын шуурхай хуралд танилцуулж байх</li> <li>✓ Өргөдөл, гомдол, албан бичгийг шийдвэрлэх явцад зөрчил гаргасан албан тушаалтан, удирдах ажилтнуудыг улирлын үр дүнгийн урамшууллаас зөрчил тус бүрээр оноо хасч тооцож байх зохицуулалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.</li> </ul>
-----	---	---

- ✓ Өргөдөл гомдол, албан бичгийг шийдвэрлэх явцдаа зөрчил гаргахгүй ажиллах талаар болон баримт бичгийн стандарт сэдвээр удирдах ажилтнууд болон захиргааны ажилтнуудад сургалт зохион байгуулан ажилласан.
- ✓ Ёс зүйн дэд хороо болон Нарны шаргал тусгал Төрийн бус байгууллагатай хамтран 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр "Эмч, эмнэлгийн ажилчдын харилцаа, хандлага мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх" зорилгоор Хэвтэн эмчлүүлэх тасаг, Хүлээн авах-яаралтай тусламжийн тасгийн эмч, ажилчдад сургалт зохион байгуулан ажилласан.

- ✓ Мөн Ёс зүйн дэд хорооноос "Өгөх нь авахаас илүү ерөөлтэй талархлын аян"-ыг 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрүүдэд Эрүүл мэндийн төвийн нийт эмч, эмнэлгийн ажилтнуудын дунд зохион байгуулан ажилласан.

Нийслэлийн эрүүл мэндийн газрын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 01/1047 дугаар албан бичиг, Хан-Уул дүүргийн засаг даргын тамгын газрын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 03/667 дугаар албан бичгийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хан-Уул Эрүүл мэндийн төвийн албан хаагчдын сажилга хариуцлагыг өндөржүүлэх, ажлын цаг ашиглалтыг сайжруулах, хяналт тавих, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, төрийн албан хаагчдын харилцаа хандлага, хувцаслалтын соёл, ёс зүйн хэм хэмжээг сахин ажиллах зорилгоор Төвийн даргын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн "Бид иргэдээ сонсож, шийднэ" тушаалаар 9 арга хэмжээ бүхий төвлөлтөгөө гарган ажиллаж байна.

**Мөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг Тэгш хүртээмжтэй-Оновчтой тусламж үйлчилгээний хүрээнд:**

- AI Виртуаль хөтөч
- Тусгай хэрэгцээт дуудлага
- Брайл шал
- Брайл самбарыг байршуулан ажиллаж байна.

**Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүрээнд Эмнэлэг - Халдваргүй орчин**

"Ожут фэйшн" ХХК-аар хэвтэн эмчлүүлэх тасаг, диалез, эрчимт эмчилгээ, хүлээн авах яаралтай тусламжийн тасгийн бүх зөөлөн эдлэлд азон бүхий дезкамерын ариутгал

халдваргүйтлийг хуваарийн дагуу өдөр тутам хийлгэж, хэвтэн эмчлүүлэгчдэд хэрэглүүлдэг болсон. 2024 оны 12 дугаар сараас эхлэн орны цагаан хэрэглэл, өвчтөний хувцас (өмд, халад, талчик)-ийг эмнэлгээсээ хангадаг болж 2 ээлжийн хангалтыг хийсэн.

- ✓ Ариутгалын өрөө
- ✓ Хөнжил-100ш /2 ээлжийн 2 сард
- ✓ Гудас-100ш/ 3 ээлжийн
- ✓ Зөөлөн эдлэл 200ш /сард
- ✓ Эм ажилчдын хувцас-200хос /12 сард
- ✓ Эмчлүүлэгчийн иж бүрэн хувцас, углааш 80хос (2 ээлжийн)

#### **Ахмадаа анхаарч-Ирээдүйгээ бүтээе 2024-2030**

Хан-Уул дүүргийн төвийн бүсийн 10 хороод нийт **13387** ахмадтай. Эрүүл мэндийн яамнаас 2025 оны 2 болон 3 дугаар сарыг "Ахмадын эрүүл мэндийг дэмжих сар" болгож ахмадын урьдчилан сэргийлэх үзлэгийг УНТЭ, ГССҮТ, ХСҮТ, СЭМҮТ, УПТЭ-тэй хамтран зохион байгуулж ажиллаж байна. Нийт **6695** ахмад үзлэг хийлгэх хүсэлт өгсөн.

#### **Эрүүл ээж-Эрүүл гэр бүл 2024-2030**

2028 он гэхэд Хан-Уул дүүргийн эмэгтэйчүүд умайн хүзүүний хорт хавдар хожуу оношлогдохгүй, нас баралтгүй болохоор ажиллаж байна. 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаа

- ✓ Амбулатори -54
- ✓ Эрт илрүүлэгээр-135

Нийт-**261** умайн хүзүүний эсийн шинжилгээ болон AI суурилсан умайн хүзүүний дурангын оншилгоонд хамрагдсан байна. Үүнээс:

- ✓ Abnormal -21
- ✓ Atypical -44

✓ Nomal -196 байна

Нийт хамрагдалтын **65 буюу 24.9%** өөрчлөлттэй гарсан байна.Мөн умайн хүзүүний эрт илрүүлэг болон эсийн шинжилгээг Дүүргийн Эрүүл мэндийн төвийн эх барих эмэгтэйчүүдийн эмч нар Өрхийн эрүүл мэндийн төвүүд дээр 2025 оны 05 дугаар сарын 05,16,23,24,30,31-ний өдрүүдэд үзлэг, шинжилгээ, оношилгоог хийн ажиллаж байгаа бөгөөд 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар нийт 1240 эмэгтэйчүүд хамрагдаад байна.

**Гарсан үр дүн:**

Төрийн албаны нэгдсэн систем Egr.uiaapbaatar.mn систем болон иргэнээс амаар болон бичгээр ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар гомдол, санал, хүсэлт, талархалыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад талархалын тоо 9%-иар өссөн, гомдол 8%-иар буурсан үзүүлэлттэй байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2 хоногтой, шийдвэрлэлтийн хугацаа болон өргөдлийн хаалтыг хууль эрх зүйн үндэслэлтэй хааж иргэн болон хуулийн этгээдээс өргөдөл гомдол гаргахгүй байх талаар анхаарч ажиллаж байна.

**Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл байхгүй, шийдвэрлэх явцад зөрчил гаргасан албан тушаалтан байхгүй байна.**

ХУД-чийн үндсэн үзүүлэлт

2025 оны эхний 5 сар

	Асуулт	2024 оны эхний 5 сар		2025 оны эхний 5 сар		Зөрүү
		Бодит тоо	10000-д эзлэх хувь	Бодит тоо	10000-д эзлэх хувь	
1	Хүн ам	248349		265793		17444
2	Бүгд үзлэг	36150		449583		413433
3	нийт төрсөн эх	1920		1823		-97
4	амьд төрсөн нярай	1942		1831		-111
5	амьд төрсөн нярай	365		389		24
6	нийт нас баралт	21	10.8	15	10.3	11.9
7	үүнээс 0-1 насны эндэгдэл	4	2.1	2	1.1	1.4
8	1-5 насны эндэгдэл	0	0	1	54.6	30.4
9	эхийн эндэгдэл	6	3.1	6	3.3	5
10	амьгүй	3	0.2	2	0.1	0.3
11	гэрлийн төрөлт	8	0.4	4	0.2	0.6
12	үзүүлээгүй	888	35.8	1731	65.1	82.8
13	нийт халдварт өвчин	5	0.2	15	0.6	0.42
14	гепатит	54	2.2	49	1.8	1.8
15	цусан суулга	1	0	792	29.8	23.6
16	улаанбурхан	42	1.7	24	0.9	1.19
17	улаан эсэргэнэ	9	0.4	11	0.4	0.7
18	сальмонеллез	431	17.4	354	13.3	16.61
19	салхинцагц	20	0.8	5	0.2	0.2
20	гахайн хавдар	6	0.2	6	0.2	0.3
21	елом	1	0	3	0.1	0
22	хачигт рикетсиоз	1	0	0	0	-1
23	бруцеллэз	9	0.4	18	0.7	1.2
24	хоолны хордлого	133	5.4	74	2.8	2.57
25	халдварын гаралтай суулга	0	0	82	3.1	3.8
26	ГХА өвчин	0	0	68	371.4	445.7
27	Бусад халдварт өвчин	0	0	89	3.3	2.9
28	Энтеровирус халдвар	1	0	0	0	0
29	төдорхойгүй	55	2.2	44	1.7	6.2
30	Эритема	32	1.3	28	1.1	0
31	Ковид-19	5	0.2	2	0.1	4.3
32	тэмбүү	84	3.4	57	2.1	3.5
33	төрөлхийн тэмбүү	1767	70.3	1777	70.3	-10
34	заг хүйтэн	1760	70.3	1755	70.3	-5
35	мөөгөнцөр	12472	50.2	11900	47.6	-572
36	трихоманназ	19.6	0.8	17.2	0.7	13.6
37	шинээр сурьээ	7.1	0.3	6.7	0.3	6
38	хэвтсэн	8	0.3	41	1.6	0.7
39	гарсан	0	0	6	0.2	19.1
40	ашигласан ор хоног	0	0	6	0.2	19.1
41	орны эргэлт	0	0	6	0.2	19.1
42	дундаж ор хоног	0	0	6	0.2	19.1
43	нас баралт	0	0	6	0.2	19.1
44	хоног болоогүй	0	0	6	0.2	19.1

Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл

1.9

100%

1.10	<p>Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр</p>	<p>Иргэдэд олон нийтэд чиглэсэн халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх 13 сэдвээр 71 удаагийн сургалт зохион байгуулж 17549 иргэн хамруулсан байна.</p> <p><a href="https://www.facebook.com/health.promotion.center">https://www.facebook.com/health.promotion.center</a> цахим хуудсаар Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс болон Нийслэлийн эрүүл мэндийн газраас бэлтгэн халдварт бус өвчнөөс сэргийлэх чиглэлээр гаргасан 10 төрлийн зурагт хуудсыг байршуулж 2079 хандалт авсан байна. Мөн хуудсанд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн төв болон Халдварт өвчин судлалын үндэсний төв зэрэг байгууллагаас гарсан 42 төрлийн зурагт хуудсыг байршуулж 10211 хандалт авсан байна.</p> <p><a href="https://www.facebook.com/khuemt.hospital">https://www.facebook.com/khuemt.hospital</a> цахим хуудсанд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Эрүүл мэндийн төвийн эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн багийн эмч нар хиймэл оюун ухаанд суурилсан AI технологи ашиглан Умайн хзүүний хорт хавдраас сэргийлэх үзлэг эсийн шинжилгээ</li> <li>✓ Хан-Уул дүүргийн "Шүд угаалтын аварга" шалгаруулах тэмцээн</li> <li>✓ Угаарын хийн эрсдэлээс сэргийлье</li> <li>✓ Ахмадын эрүүл мэндийг дэмжих</li> <li>✓ Өсвөр үеийн өсөлт хөгжлийн үнэлгээ сэдэвт богино хэмжээний бичлэг бэлтгэн цацсан байна. Нийт хандалтын тоо 100.000</li> </ul> <p>2025 оны эхний 4 сарын байдлаар Хан-Уул дүүргийн хэмжээнд халдварт бус өвчний эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд хамрагдвал зохих 18-аас дээш насны нийт 162259 хүн ам 35-аас дээш нас 108192 хүн ам байна. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Элэгний хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан ард иргэдийн тоо эхний 4 сарын хувьд 12370 хүн үүнээс хүйсийн байдлаар харгалзаж үзвэл эрэгтэй 4879, эмэгтэй 7491 эмэгтэйчүүдийн хамрагдалт 35%-иар илүү байна. Үүнээс хавдар илэрсэн тохиолдол байхгүй. 2024 онд эрт илрүүлэгт 9115 иргэд хамрагдаж байсан бол 2025 оны эрт илрүүлэгт хамрагдалт 11%-иар өссөн дүнтэй байна.</li> <li>✓ Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт хамрагдвал зохих 15547 эмэгтэйчүүдээс эхний 4 сард хамрагдсан 4452 эмэгтэй 29%-тай байна. 2024 онд хамрагдсан иргэд 3306 байсан бол 2025 онд хамрагдсан эмэгтэйчүүд 9%-иар өссөн дүнтэй байна.</li> <li>✓ Хөхний эрт илрүүлэг үзлэгт оношилгоонд хамрагдвал зохих 60677 эмэгтэйчүүдээс хамрагдсан 23753 эмэгтэй эрт илрүүлгийн хувь 39%-тай байна. 2024 онд эрт илрүүлэгт 16081 хамрагдаж байсан бол 2025 оны эхний 4 сарын байдлаар 10%-иар өссөн дүнтэй байна.</li> </ul>	100%
------	--	---	------

		<ul style="list-style-type: none"> <li>✓ Артерийн даралт ихсэх өвчний арт илрүүлэг, үзлэг оношилгоонд 18-аас дээш насны хамрагдвал зохих 162259 иргэд эхний 4 сарын байдлаар хамрагдсан 44368 иргэд 27% 2024 онд эрт илрүүлэгт 38330 иргэд хамрагдаж байсан бол 2025 онд 2,1%-иар хамрагдалт нэмэгдсэн байна.</li> <li>✓ "Чихрийн шижин, хэв шинж" эрт илрүүлэгт хамрагдвал зохих 35-аас дээш насны хамрагдвал зохих 108192 иргэн хамрагдаж эхний 4 сарын байдлаар 37401 иргэн хамрагдаж 35% 2024 онд эрт илрүүлэгт 28951 иргэд хамрагдаж байсан бол 2025 онд 5,9%- иар хамрагдалтын тоо өссөн дүнтэй байна.</li> </ul>	
<b>Хэсгийн дундаж хувь:98.3%</b>			
<b>ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦИЙН ИЛ ТОД БАЙДАЛ;</b>			
2.1	Хүний нөөцийн ил тод байдал;	<p>Эрүүл мэндийн төв нь 2025 онд нийт 223 ажилтантай ажиллаж байгаагаас удирдах ажилтан 11, их эмч 76, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн 55, эм зүйч 5, эмнэлгийн бусад ажилтан 65, гэрээт ажилтан 11 тус тус ажиллаж байна. Нийт эмч мэргэжилтний 188 нь эмэгтэй, 35 нь эрэгтэй ажилтан байна. Эрүүл мэндийн төв нь байгууллагын нээлттэй ил тод байдлыг байгууллагын ил тодын самбарт 14 хоног тутам Шинэчлэн байршуулан ажиллаж байна.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Хүний нөөцийн ил тод байдал</li> <li>➤ Төсөв санхүүгийн ил тод байдал</li> <li>➤ Ёс зүйн ил тод байдал</li> <li>➤ Хууль эрх зүйн ил тод байдал</li> <li>➤ Тайлан төлөвлөгөөний ил тод байдал</li> <li>➤ Мэдээллийн лавлагааны ил тод байдал</li> <li>➤ Өргөдөл гомдлын ил тод байдлыг байршуулан ажиллаж байна.</li> </ul> <p>Хүний нөөцийн ил тод байдлын хүрээнд сул орон тооны зарыг тухай бүр шинэчлэн байршуулан ажиллаж байна. Байгууллагын болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, вэб сайт, цахим хуудсанд 2025 оны эхний хагас жилийн байдлаар ажлын байрны зарыг 24 удаа байршуулж, 35 хүнийг орон тоогоор авч ажиллуулаад байна. Үүнд:</p>	98%

	<ul style="list-style-type: none"> <li>✓ Дүрс оношилгооны эмч</li> <li>✓ Чанарын менежер</li> <li>✓ Эрсдлийн менежер</li> <li>✓ Хүний нөөцийн мэргэжилтэн</li> <li>✓ Мэдрэлийн эмч</li> <li>✓ Эрчимт эмчилгээний эмч</li> <li>✓ Гэмтлийн эмч</li> <li>✓ Лабораторийн эмч</li> <li>✓ Шүдний эмч</li> <li>✓ Хүүхдийн эмч</li> <li>✓ Дотрын эмч</li> <li>✓ Хавдрын эмч</li> <li>✓ Ахмадын эмч</li> <li>✓ Мэдээлэл зүйн эмч</li> <li>✓ Яаралтай тусламжийн эмч</li> <li>✓ Эх барих эмэгтэйчүүдийн эмч</li> <li>✓ Лабораторийн техникч-2</li> <li>✓ Тархвар судлаач</li> <li>✓ Эх барих эмэгтэйчүүдийн бага эмч</li> <li>✓ Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер</li> <li>✓ Эм зүйч</li> <li>✓ Нүдний сувилагч</li> <li>✓ Шүдний сувилагч</li> <li>✓ Эрэмбийн сувилагч</li> <li>✓ Ээлжийн сувилагч-2</li> <li>✓ Сүлжээний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн</li> <li>✓ Эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн ажилтан-2</li> <li>✓ Жолооч</li> <li>✓ Туслах сувилагч</li> <li>✓ Хөтөч</li> <li>✓ Үйлчлэгч-2 тус тус авч ажиллуулаад байна.</li> </ul>	
--	--	--

2.2	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам	<p>Хүүхэд асрах чөлөөнөөс-3 тус тус нийт 38 хүнийг авч ажиллуулалаад байна.</p> <p>Эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/79 дугаар тушаалаар баталсан "Ажилтан сонгон шалгаруулах журам"-ын дагуу ажлын байрны сонгон шалгаруулалт хийж, хүний нөөцийн бүрдүүлэлтийг хийн ажиллаж байна.</p>	100%
2.3	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм	<p>Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/256 дугаар тушаалын 6.2 дахь хэсэг, Монгол улсын ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолыг дагуу Төвийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 22-ний өдрийн А/99 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталсан. Ёс зүйн Дэд Хороо нь 7 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус хамтын удирдлагын байгууллага юм.Хороо нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой асуудлууд, үйлчлүүлэгч ба эмч ажилчдын харьцаа хандлага ёс зүй, нийгмийн эрсдэлт хүчин зүйлийг эрт илрүүлэх засаж сайжруулах, давтан гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулан ажиллаж байна.</p>	98%
2.4	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам	<p>Хан-Уул Эрүүл мэндийн төвийн зорилт, чиг үүргийг үр ашиг, үр нөлөөтэй боловсруулж, хэрэгжүүлэх, байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратеги зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах, сургах, мэргэшүүлэх, үнэлэх, хэрэгцээг тодорхойлох, эрсдлийг тооцох, өөрчлөлт шинэчлэлтэд зохицож чадах үнэт зүйлс, мэдлэг чадвар бүхий хүний нөөцийг төлөвшүүлэх, удирдах ажилтны манлайлах үр чадварыг нэмэгдүүлэх, хоорондын уялдаа харилцаа холбоог бэхжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилгоор Эрүүл мэндийн төвийн даргын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/55 дугаар тушаалаар 2024-2028 онд хэрэгжүүлэх Хүний нөөцийн хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлэн ажиллаж байна.Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтэд Эрүүл мэндийн төвийн удирдлагууд болон хүний нөөцийн алба, ёс зүйн хэсгийн хороо, шинжилгээ үнэлгээний нэгж, шалгуур үзүүлэлт, журмын дагуу үнэлэлт, дүгнэлт өгч хяналт хийн ажиллаж байна.</p>	98%
2.5		<p>Сул орон тооны зарыг тухай бүр шинэчлэн ил тод байдлын самбар болон байгууллагын цахим хуудсанд байршуулж байна. Эрүүл мэндийн төв нь байгууллагын нээлттэй ил тод байдлыг байгууллагын ил тодын самбарт 14 хоног тутам шинэчлэн байршуулан ажиллаж байна. Үүнд:</p>	100%

	<p>Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ</p>	<ul style="list-style-type: none"> <li>➤ Хүний нөөцийн ил тод байдал</li> <li>➤ Төсөв санхүүгийн ил тод байдал</li> <li>➤ Ёс зүйн ил тод байдал</li> <li>➤ Хууль эрх зүйн ил тод байдал</li> <li>➤ Тайлан төлөвлөгөөний ил тод байдал</li> <li>➤ Мэдээллийн лавлагааны ил тод байдал</li> <li>➤ Өргөдөл гомдлын ил тод байдлыг байршуулан ажиллаж байна.</li> </ul> <p>Хүний нөөцийн ил тод байдлын хүрээнд сул орон тооны зарыг тухай бүр шинэчлэн байршуулан ажиллаж байна.</p> <p>Албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 395 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн төвийн даргын 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/29 дүгээр тушаалаар Эмч, эмнэлгийн ажилчдын улирлын үр дүнг тооцох, дүгнэх шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн баталж, эмч ажилчдын ажлын гүйцэтгэлийг улирлаар дүгнэж, урамшууллыг олгон ажиллаж байна.2025 оны эхний хагас жилийн байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ 2025 оны 1 дүгээр улиралд 220 албан хаагчдад үр дүнгийн урамшуулал <b>172.361.540</b> төгрөгийг олгоод байна.</li> </ul>	2.6	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам	-	100%
<b>Хэсгийн дундаж хувь:99%</b>						
<b>ГУРАВ. ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ИЛ ТОД БАЙДАЛ</b>						
3.1	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл	Хан Уул эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн даатгалыг сангаас 11,1 тэрбум төгрөгийн санхүүжилт авч төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 1,3 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 12,0 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Тухайн тайлант онд 13,3 тэрбум төгрөгөөр төсөв батлагдсан бөгөөд сар бүр төлөвлөсөн төлөвлөгөөний дагуу урсгал үйл ажиллагаанд зарцуулалт хийн ажиллаж байна.	98%			100%
3.2	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан	Төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг шилэн дансанд байршуулж мөн байгууллагын хагас жилийн тайланг байгууллагын цахим хуудсанд байршуулж иргэд болон бэлтгэн нийлүүлэгчдийг санхүүгийн шаардлагатай мэдээллээр ханган ажиллаж байна.				

3.3	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	Тус Эрүүл мэндийн төвийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдал, төсөв, санхүү, өмч хөрөнгө, нягтлан бодох бүртгэл, хэмнэлтийн тухай Монгол Улсын хууль тогтоомж түүнд нийцүүлэн төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан заавар, журамтай нийцэж буй эсэхэд үнэлэлт дүгнэлт, зөвлөмж өгч мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах зорилгоор 2024 оны үйл ажиллагаанд аудит, хяналт шалгалтыг хийсэн болно. Хяналт шалгалтаар акт 3, Албан шаардлага 7 илэрсэн.	100%						
3.4	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	Сангийн сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар баталсан төлбөртэй тусламж үйлчилгээний тарифыг дагаж мөрддөг бөгөөд энэхүү тушаалд нэмэлт өөрчлөлт орох бүрт Эрүүл мэндийн төвийн даргын тушаал гарган шинэчилсэн тарифыг дагаж мөрдөн ажиллаж байна.	100%						
3.5	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжилт авч ажиллаж байна. Мөн суудлын автомашин ашигладаггүй, томилолтын зардал гаргаагүй байна.	100%						
3.6	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	Байгууллагын санхүүгийн ил тод байдлыг хангах, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдлийг бууруулах ажлын хүрээнд дараах мэдээллийг цахим хуудсанд байршуулан ажилласан. <table border="1" data-bbox="805 257 933 1512"> <thead> <tr> <th data-bbox="805 1377 837 1512">№</th> <th data-bbox="805 593 837 1377">Шилэн дансны мэдээлэл</th> <th data-bbox="805 257 837 593">Мэдээлсэн байдал</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="837 1377 869 1512">1</td> <td data-bbox="837 593 869 1377">5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ мэдээлэл</td> <td data-bbox="837 257 869 593">135</td> </tr> </tbody> </table>	№	Шилэн дансны мэдээлэл	Мэдээлсэн байдал	1	5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ мэдээлэл	135	100%
№	Шилэн дансны мэдээлэл	Мэдээлсэн байдал							
1	5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ мэдээлэл	135							
3.7	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	Шилэн дансны цахим хуудсанд <a href="https://www.shilendans.gov.mn/org/">https://www.shilendans.gov.mn/org/</a> -нд тогтмол байршуулж шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Шилэн дансанд мэдээллийг тогтмол байршуулахаас гадна Хан-Уул эрүүл мэндийн төв нь холбогдох мэдээллүүдийг байгууллагын цахим хуудас <a href="http://www.huemn.ub.gov.mn">http://www.huemn.ub.gov.mn</a> сайт, болон байгууллагын ил тод байдлын самбарт тухай бүр байршуулсан байна. <table border="1" data-bbox="1093 257 1220 1512"> <thead> <tr> <th data-bbox="1093 1377 1125 1512">№</th> <th data-bbox="1093 593 1125 1377">Шилэн дансны мэдээлэл</th> <th data-bbox="1093 257 1125 593">Мэдээлсэн байдал</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="1125 1377 1157 1512">1</td> <td data-bbox="1125 593 1157 1377">Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зардлагын мөнгөн гүйлгээг</td> <td data-bbox="1125 257 1157 593">25</td> </tr> </tbody> </table>	№	Шилэн дансны мэдээлэл	Мэдээлсэн байдал	1	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зардлагын мөнгөн гүйлгээг	25	100%
№	Шилэн дансны мэдээлэл	Мэдээлсэн байдал							
1	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зардлагын мөнгөн гүйлгээг	25							

3.8	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, ер, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	Тухайн тайлант онд ажилчдын үр дүнгийн тушаал, тэтгэмж олгох тухай тушаал шийдвэрүүдийг хавсаргасан.	100%
3.9	Шилэн дансны хөтөлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, заалтыг хэрэгжүүлэх зорилгоор <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэг хүлээдэг. Хан-Уул Эрүүл мэндийн төв нь тайлант онд мэдээллэх ёстой 171 мэдээллээс цаг хугацаандаа 64, хугацаа хоцорсон 3 мэдээллийг байршуулан ажиллаж байна.	90%
3.10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан	Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа эмнэлгийн байгууллагуудын нэгтгэсэн төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бараа ажил үйлчилгээ худалдан авах тендерийн баримт бичгийг боловсруулж шалгаруулалтанд явуулсан. Нийт эм, эмнэлгийн хэрэгслийн тендерийн 51 багцаас шалгаруулсан. Үүнээс 1 оролцогчтой 21 багц, 1-с дээш оролцогчтой нийт 25 багц, санал ирүүлээгүй дахин зарлагдах 5 багц байна.	95%
3.11	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан хийгдээгүй байна.	100%

3.12	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр худалдан авах этгээдийг мэргэжилт, ажиллагааны мэргэжилт, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл	Байгууллагын үнэлгээний хороог 5 гишүүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан ба худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан онлайн сургалтанд хамрагдан АЗ сертификатын эрх олгох шалгалт өгч тэнцсэн гишүүдээс үнэлгээний хороо бүрдсэн.	100%
3.13	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн	Тайлант онд төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр байхгүй болно.	100%
3.14	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан	Мэдээлэл хариуцагчийн ажлын тайланг жилийн эцэст тогтмол гаргаж үр дүнг дүгнэдэг. Тасаг нэгжүүд өөр өөрсдийн үйл ажиллагааны чиглэлд хамаарах мэдээ мэдээллийг байгууллагын цахим хаяганд байршуулж мэдээллээр ханган ажиллаж байна.	100%
3.15	Хууль тогтоомжид заасан бусад	Тайлант онд дээд шатнаас ирүүлсэн тушаал, шийдвэр чиглэлийг даган ажилласан.	100%
<b>Хэсгийн дундаж хувь: 97.4%</b>			
<b>ДӨРӨВ. ҮЗҮҮЛЖ БАЙГАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ</b>			
4.1	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт	Төрийн албаны вэб сайтыг стандарт MNS 6285:2017 баримт бичигт тусгагдсан өөрчлөлт нь энэ стандартыг баримтлан 2017-2025 онд тухай бүр шинэчлэн ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 201 дүгээр тогтоолоор батлагдсан Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журмын дагуу тайлан мэдээг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. Хан-Уул эрүүл мэндийн төвийн <a href="http://huemn.ub.gov.mn">huemn.ub.gov.mn</a> албан ёсны цахим хуудсандаа 2025 онд хагас жилийн байдлаар 151 мэдээ нийтэлсэн. Цахим хуудасны <a href="http://huemn.ub.gov.mn">huemn.ub.gov.mn</a> хандалт 2025 оны хагас жилийн байдлаар өссөн дүнгээр 250356 хэрэглэгчийн хандалттай байна. Цахим хуудсаа сурталчлах зорилгоор социал медиа хуудсуудыг түлхүү ажиллуулж эхэлсэн. Байгууллагын албан ёсны цахим хуудас ( <a href="https://www.facebook.com/huemn.ub">facebook page</a> ) Хан-Уул эрүүл мэндийн төвийн дагагчийн тоо 25000 (like) үзүүлттэй байна, хувь хүнд чиглэсэн аккаунт ( <a href="https://www.facebook.com/huemn.ub">facebook account</a> ) Эрүүл мэндийн төвийн хуудсыг хөтлөөд 5000 найзтай үйл ажиллагаа тогтмолжсон.	100%

	<p>Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.</p>	<p>Эрүүл мэндийн сайдын А/554 дүгээр тушаалын шалгуураар магадлан итгэмжлэлийн шинжээч нарын дүгнэлтээр Эрүүл мэндийн сайдын 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн А/108 дугаар тушаалаар "Батламжийн дугаар 57/2023" 3 жилийн хугацаатай батламжлууллаа. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдөр дугаар №ЭХ-02-22-2759 5 жилийн хугацаатай авсан.</p>	100%
--	---	--	------

**Хэсгийн дундаж хувь: 100%**

<p><b>ТАВ. БУСАД МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ</b></p>												
5.1	<p>Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал</p>	<p>Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон ажлын цаг ашиглалтын журмыг шинэчлэн боловсруулахдаа байгууллагын дотоод групп дээр нийт албан хаагчдаас нээлттэй санал, асуулга авч тухайн гарсан саналыг нэгтгэн, хууль тогтоомжид заасны дагуу шинэчлэн боловсруулж Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн "Ажлын цаг ашиглалтын журам батлах тухай" А/60 дугаар тушаалаар батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	100%									
5.2	<p>Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт</p>	<table border="1"> <tr> <td data-bbox="774 1220 1460 1534">1</td> <td data-bbox="774 1019 1460 1220">AR цахим хөтөч</td> <td data-bbox="774 100 1460 1019"> <p>Хан-Уул дүүрэгт 4985 тусгай хэрэгцээт иргэн бүртгэлтэй. Энэхүү хэрэгцээ, шаардалгад үндэслэн Хан-Уул Эрүүл мэндийн төв нь 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрөөс тусламж үйлчилгээндээ AR буюу Вертуаль Хөтөч ажиллуулж эхэлсэн бөгөөд нийт хандалтын тоо 1240 байна.</p> </td> </tr> <tr> <td data-bbox="774 1220 1460 1534">2</td> <td data-bbox="774 1019 1460 1220">Disom зураг хадгалах арга</td> <td data-bbox="774 100 1460 1019">2025 оны эхний хагас жилийн байдлаар 6874 зураг хадгалсан байна.</td> </tr> <tr> <td data-bbox="774 1220 1460 1534">3</td> <td data-bbox="774 1019 1460 1220">Төрийн цахим шуудан</td> <td data-bbox="774 100 1460 1019">2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж буй Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 30.2-т "Төрийн</td> </tr> </table>	1	AR цахим хөтөч	<p>Хан-Уул дүүрэгт 4985 тусгай хэрэгцээт иргэн бүртгэлтэй. Энэхүү хэрэгцээ, шаардалгад үндэслэн Хан-Уул Эрүүл мэндийн төв нь 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрөөс тусламж үйлчилгээндээ AR буюу Вертуаль Хөтөч ажиллуулж эхэлсэн бөгөөд нийт хандалтын тоо 1240 байна.</p>	2	Disom зураг хадгалах арга	2025 оны эхний хагас жилийн байдлаар 6874 зураг хадгалсан байна.	3	Төрийн цахим шуудан	2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж буй Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 30.2-т "Төрийн	100%
1	AR цахим хөтөч	<p>Хан-Уул дүүрэгт 4985 тусгай хэрэгцээт иргэн бүртгэлтэй. Энэхүү хэрэгцээ, шаардалгад үндэслэн Хан-Уул Эрүүл мэндийн төв нь 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрөөс тусламж үйлчилгээндээ AR буюу Вертуаль Хөтөч ажиллуулж эхэлсэн бөгөөд нийт хандалтын тоо 1240 байна.</p>										
2	Disom зураг хадгалах арга	2025 оны эхний хагас жилийн байдлаар 6874 зураг хадгалсан байна.										
3	Төрийн цахим шуудан	2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж буй Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 30.2-т "Төрийн										

			байгууллага, албан тушаалтан хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд цахим хэлбэрээр харилцахдаа албаны цахим шуудан ашиглана" хэмээн заасан. Энэ дагуу эрүүл мэндийн төвийн 154 албан хаагчдад цахим шуудан нээж өгсөн байна.	
5.3	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлт явуулаагүй болно.	80%	
5.4	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл	Хан-Уул Эрүүл мэндийн төвийн "Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ"-ний дугаар-000437267 Засаг даргын 2014 оны 06 сарын 17-ны өдрийн А/501 тоот шийдвэрийг үндэслэн нэгж талбарын 178015/0279 дугаар бүхий 4000 м <sup>2</sup> га газрыг 15 жилийн хугацаатай Хан-Уул дүүргийн 2-р хороонд "Эмнэлгийн үйлчилгээ" зориулалтаар эзэмшүүлэх	95%	
5.5	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий хуулийн этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн	Хан-Уул Эрүүл мэндийн төв нь Монгол улс Улаанбаатар хот Хан-Уул дүүргийн 20-р хороо Чингисийн өргөн чөлөө өөрийн байранд үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд дүүргийн хүн амд хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Тус Эрүүл мэндийн төв нь Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2008 оны 02 дугаар сарын 29-ны өдрийн баталсан дүрмийг баримтлан үйл ажиллагаагаа явуулж байна. Тухайн тайлант оны эхний хагас жилийн байдлаар 6.2 тэрбум төгрөгийн санхүүжилтээ татан аваад ажилласан байна. Цалин хөлс 3,1 тэрбум, нийгмийн даатгалын шимтгэл 305,0 сая төлбөрийн татварыг төсөвт төвлөрүүлэн ажиллаж байна.	98%	

	<p>татварын хэмжээ, ногдол ашиг</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эхийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл</p>	<p>Эрүүл мэндийн тухай хуулийн 17.4 дэх хэсэгт нэгдсэн эмнэлгийн удирдлагыг эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс томилсон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ гэж заасны дагуу Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн Хамтран ажиллах албан тоотод дурдсан тус эмнэлэгийг төлөөлөх 3 гишүүнийг Эрүүл мэндийн тухай хуулийн 17.9.2 дэх хэсэгт заасны дагуу сонгон шалгаруулж явуулсан. 3 гишүүнийг сонгон шалгаруулж явуулахдаа Эмнэлэгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийг удирдлага болгон сонгон шалгаруулалтаа явуулж Доорхи гишүүдийг сонгосон.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Үйлчилгээний албан хаагчдыг төлөөлж Д.Молор-Эрдэнэ</li> <li>• Эмч нарыг төлөөлж Г.Төрбат</li> <li>• Сувилагч нарыг төлөөлж Сүнжидмаа</li> </ul> <p>ТУЗ-Д 3-н гишүүнийг сонгон шалгаруулж 2022 оны 04 сарын 27-ны А/252 тоот Дүүргийн засаг даргын захирамжаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэгшигчийг батламжилсан. ТУЗөвлөл хуралдаагүй, удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлага сонгоогүй болно.</p>	96%
5.7	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл</p>	<p>Төрийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулахдаа нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг баримтлан анхан шатны баримтыг бүрдүүлж, эд хариуцагчийн картаар баталгаажуулан ашиглуулдаг. Хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан мөн ашиглах хугацаа дуусаагүй болоогүй боловч эдэлгээний явцад дахин ашиглах боломжгүй болсон хөрөнгийг нийслэлийн өмчийн харилцааны газарт албан бичгээр мэдэгдэн байгууллагын зөвлөлийн хурлаар оруулж тухайн хөрөнгийг нийслэлийн өмчийн харилцаана газарт хүлээлгэн өгдөг. Ашиглалтнаас гарсан хөрөнгийн худаддан борлуулдаггүй болно.</p>	100%

5.8	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл	Эрүүл мэндийн төвийн амбулаторийн 3-н давхарт байрлаж байсан сүрьеэгийн диспансерийг нисэх салбарт тусдаа гаргаж, халдварын нөхцөл байдлын үүсэх эрсдэлээс хамгаалсан.2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01/146 дугаар албан бичгээр Дүүргийн Төлөвлөлт гүйцэтгэл удирдлагын хэлтэст Сүрьеэгийн диспансерийн барилгын дээвэр, агааржуулалтын засварыг хийлгэх тухай саналаа мэргэшлийн төсөвчинөөр тооцуулж, саналын хамт хүргүүлж, нийслэлийн төсөвт суулгах хүсэлтээ өгсөн.	100%
5.9	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлтээр 2023 онд Барилгын гадаад талбай, барилгын гадна пасадын ажлыг 100 хувь дуусгаж комиссын шийдвэрээр хүлээн авсан.	100%
5.10	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ хийгээгүй болно.	50%
5.11	Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл	Мэдээллийн сан бүхий Ehealth программ хангамж нь нээлттэй өгөгдөл байхгүй.	100%
5.12	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил,	Хамтын гэрээний 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу Байгууллагын захиалгаар урт хугацааны сургалтанд хамрагдаж байгаа ажилчдын сургалтын хугацааны эхний 3 сарын үндсэн цалинг бүтнээр олгож байна. Эхний хагас жилийн байдлаар байгууллагын захиалгаар	100%

	суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт	<ul style="list-style-type: none"> <li>➤ Хүлээн авах, яаралтай тусламжийн эмч А.Наранхүү Яаралтай тусламжийн эмчээр,</li> <li>➤ Эрчимт эмчилгээний эмч Б.Халиун Гемодиализийн эмчээр</li> <li>➤ Хөдөлгөөн засалч Б.Цогзолмаа нь бариа заслын сувилагчаар тус тус суралцаж байна.</li> </ul>	
5.13	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл	Хууль болон олон улсын гэрээгээр хуулийн дагуу нээлтэй үйл ажиллагаа явуулдаг.	98%
<b>Хэсгийн дундаж хувь: 93.6%</b>			
Хэрэгжилтийн дундаж хувь: 97.6%			



ХЯНАСАН  
ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ ДАРГА **Ц.ЭНХБЯЯСГАЛАН**

НЭГТГЭСЭН:  
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН *Утимаа* **Б.ЭНХЧИМЭГ**